



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2021 оны 37 болон 38 дахь долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 10-р сарын 11-нээс 10-р сарын 28-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 16 дахь дугаарыг хүргэж байна.

### 1

### ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Олон Улсын Валютын Сангийн 10-р сарын “Дэлхийн Эдийн Засгийн Төлөв” тайланд дэлхийн эдийн засаг энэ онд 5.9 хувиар, ирэх онд 4.9 хувиар өсөхөөр төсөөлжээ.** Энэ нь 7-р сарын төсөөллөөс 2021 онд 0.1 нэгж хувиар буурсан, 2022 оны хувьд өөрчлөлтгүй байна. Төсөөлөл энэ онд буурахад нийлүүлэлтийн доголдолтой холбоотойгоор хөгжингүй орнуудын өсөлтийн төлөв хүлээлтээс доогуур байх, бага орлоготой хөгжиж буй орнуудад цар тахлын нөхцөл байдал хүндэрч өсөлтийн төлөв муудсан зэрэг нь нөлөөллөө. Харин зарим түүхий эд экспортлогч эрчимтэй хөгжиж буй орнууд (ОХУ, Латин Америкийн орнууд)-ын өсөлтийн төлөв өмнөхөөс сайжирсан байна. Ерөнхийд нь дүгнэвэл цар тахлын өнөөгийн нөхцөл байдалд

улс орнуудын эдийн засаг үргэлжлэн сэргэж байгаа хэдий ч вакцинжуулалтын явцаас эдийн засгийн өсөлт голлон хамаарч байна. Түүнчлэн бодлого боловсруулагчид ажил эрхлэлтийн алгуур өсөлт, инфляцын өндөр түвшин, хүнсний аюулгүй байдлын эрсдэл, хүмүүн капиталын хуримтлал удаашрах, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон сорилтуудтай тулгарч, бодлогын сонголт хийхэд улам хүндрэлтэй болж байна. Төсөөллөөр эдийн засгийн өсөлт буурах эрсдэл нь давамгайлж байгаа бөгөөд улс орнууд бүх нийтийн вакцинжуулалтаа бүрэн хийхээс өмнө КОВИД-19-ийн илүү аюултай хувилбар дэгдэж болзошгүйг ОУВС анхаарууллаа.

**Хүснэгт 1. Дэлхийн санхүүгийн байгууллага, олон улсын агентлагуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд (хувиар)**

Байгууллагын нэрс	Төсөөлөл хийсэн огноо	2021 он					2022 он
		Дэлхийн эдийн засгийн өсөлт	БНХАУ	АНУ	Евро бүс	ОХУ-ын өсөлт	Дэлхийн эдийн засгийн өсөлт
1 OECD	10/12/2021	5.9%	8.0%	6.0%	5.0%	4.7%	4.9%
2 The EIU	10/19/2021	5.4%	7.9%	5.7%	4.8%	3.8%	4.1%
3 Conference board	10/12/2021	5.1%	8.3%	5.7%	4.7%	4.5%	
4 Euro Monitor	10/21/2021	5.7%	8.0%	5.7%	4.9%		4.8%

5	Oxford Economics	10/20/2021	5.7%				4.5%
---	------------------	------------	------	--	--	--	------

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд

- **EIU байгууллагын** 10-р сард шинэчилсэн **төсөөллөөр** дэлхийн эдийн засаг 2021 онд 5.4 хувиар, 2022 онд 4.1 хувиар өсөхөөр байна. Цар тахлын дараах эдийн засгийн эрчимтэй сэргэлт 2022 он руу үргэлжлэх төлөвтэй бөгөөд бүс нутгуудын хувьд сэргэлт харилцан адилгүй байна. Түүхий эдийн өндөр үнэ, нийлүүлэлтийн доголдоос үүдэлтэй үнийн өсөлтөөс гадна эрэлтийн шалтгаантай **инфляц өсөж байгаа нь** томоохон эдийн засагтай орнуудын Төв банкууд ирэх оноос бодлогын төлөвөө чангаруулж, эдийн засгийн **өсөлтийг хязгаарлаж болзошгүй байна**. Вакцинжуулалтын явц удаан байгаа нь вакцинд тэсвэртэй вирусын шинэ төрлийн хувилбарууд үүсч, тархах боломжийг олгож, эдийн засгийн өсөлтийг хязгаарлах гол эрсдэл болж байна. Улмаар дэлхийн хүн амын 90 хувь нь вакцинд хамрагдсан нөхцөлд нийтийн дархлаа тогтох хэдий ч энэ нь нэгэнт боломжгүй тул одоогийн вакцинжуулалтын хөтөлбөрийн гол зорилго нь КОВИД-19-ийн хүндрэлийг багасгаж, эмнэлгийн ачааллыг бууруулах, нас барах эрсдэлийг хязгаарлахад чиглэж байна.
- Фитч **Евромонитор байгууллагын** 2021 оны 10-р сарын шинэчилсэн **төсөөллөөр** дэлхийн эдийн засаг 2021 онд 5.7 хувиар, 2022 онд 4.8 хувиар өсөхөөр байна. Энэ нь өмнөх улирлын төсөөллөөс 2021 онд 0.2 нэгж хувиар муудсан, 2022 онд 0.2 нэгж хувиар сайжирсан тооцоолол юм. Мөн одоогийн цар тахлын вакцинууд дельта вирусын эсрэг 60-88 хувь үр нөлөөтэй бөгөөд эмнэлэгт хэвтэх эрсдлээс 71-96 хувь сэргийлж байгаа тухай судалгааны үр дүнтэй байна. Гэвч дельта вирусын тархалт КОВИД-19-ийн анхны вирусээс 2.5-3.0 дахин хурдтай тархаж байгаа тул

нийтийн дархлаа тогтоход дэлхийн хүн амын 90-с дээш хувь вакцинд хамрагдах шаардлагатай ажээ. Харин хөгжиж буй орнуудад вакцинжуулалтын хувь 2023 оныг хүртэл 50-с доош түвшинд байх төлөвтэй байна. Цар тахлын нөхцөл байдал төдийлөн дээрдэхгүй байгаагаас **нийлүүлэлтийн доголдол 2022, 2023 онуудад үргэлжилж, эдийн засгийн өсөлтийг хязгаарлахаар байна**. Эдийн засгийн өсөлтийн гол эрсдэл нь EIU байгууллагын адилаар КОВИД-19-ийн илүү аюултай хувилбар дэгдэх эрсдэл гэж тус байгууллага үзжээ.

*Сонгосон орнуудын эдийн засгийн үзүүлэлтүүд*

- **АНУ-ын эдийн засаг** 2-р улиралд жилийн 6.7 хувиар өссөн бол **3-р улиралд урьдчилсан дүнгээр 2.0 хувиар өслөө**. Эдийн засгийн өсөлт өмнөх улирлаас ийнхүү саарахад автомашин, түүний эд ангийн худалдан авалт буурсан, нийтийн хоол, зочид буудлын үйлчилгээний өсөлт саарч, хувийн хэрэглээний өсөлт удааширсан нь голлон нөлөөлжээ.
- **Евро бүсийн үйлчилгээний PMI индекс 9-р сард 58.6 байсан бол 10-р сард 58.5 болж аж үйлдвэрлэлийн идэвхи багаслаа**. Хэдийгээр эерэг өсөлттэй байгаа ч нийлүүлэлтийн гинжин сүлжээн дэх доголдол болон тээврийн асуудлууд даамжирч, аж үйлдвэрлэл сүүлийн 16 сарын хамгийн бага түвшинд хүрэв. Ялангуяа автомашин, түүний эд ангийн үйлдвэрлэл хамгийн ихээр буураад байна.

Эх сурвалж:

1. IMF, [World Economic Outlook – October 2021](#)
2. The Conference Board, [Global Economic Outlook](#)
3. Economist Intelligence, [Global Forecasting Service](#)



4. Oxford Economics, [World Economic Prospects](#)
5. Euro Monitor International, [Global Economic Outlook: Q4 2021](#)
6. Trading Economics, [Euro Area Manufacturing PMI](#)
7. MiningDotCom, [Iron ore price down as Beijing moves to cool coal prices](#)
8. MiningDotCom, [Australia says iron ore price expected to reach \\$150 by late 2021](#)
9. Deloitte Insights, [Global Weekly Economic Update](#)
10. OPEC, [21st OPEC and non-OPEC Ministerial Meeting concludes](#)
11. BEA, [Gross Domestic Product, Third Quarter 2021 \(Advance Estimate\)](#)

## 2

## БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

*Эдийн засгийн голлох индексүүдийн өөрчлөлт*

- БНХАУ-ын эдийн засаг 2021 оны III улиралд өмнөх улирлын Блүмберг агентлагын төсөөлөл болох 5 хувиас доогуур буюу 4.9 хувиар өссөн нь 2020 оны 3-р улирлаас<sup>1</sup> хойших хамгийн бага өсөлт болов. 2021 оны эхний гурван улирлын байдлаар БНХАУ-ын эдийн засаг өнгөрсөн оны мөн үеэс 9.8 хувиар өсөж, үүний 64.8 нэгж хувийг хувийн хэрэглээний өсөлт бүрдүүлж байна. Харин экспорт 19.9 хувиар, импорт 10.1 хувиар тэлж, худалдааны тэнцэл 433.2 тэрбум ам.долларын ашигтай гарчээ.
- БНХАУ-ын жижиглэн худалдаа 9-р сард 4.4 хувиар өссөн нь 8-р сарын 2.5 хувийн өсөлтийг давлаа. Задалж авч үзвэл үнэт эдлэл 20.1 хувь, харилцаа холбооны салбар 21 хувь, барилгын материал 13.3 хувиар өссөн бол хувцас 4.8 хувь болон авто машины борлуулалт 11.8 хувиар тус тус буурав.
- Тус улсын үл хөдлөх болон барилгын салбар агшлаа. Тодруулбал, энэ оны гуравдугаар улиралд үл хөдлөх хөрөнгийн салбар 1.6 хувиар, барилгын салбар 1.8 хувиар тус тус буурчээ. Мөн 2021 оны эхний 9 сарын байдлаар орон

сууцны худалдан авалтын хэмжээ өмнөх оноос 4.5 хувиар буурсан байна.

- БНХАУ-ын Ардын банкны төлөөлөгч Эверграндын санхүүгийн хүндрэлээс үүдсэн санхүүгийн системд учруулах эрсдэлийг тогтоон барих боломжтой бөгөөд Засгийн газар нь ямарваа нэгэн аж ахуй нэгжийг хамгаалах бус банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авна гэж мэдээлэв.

*Ган, коксжих нүүрсний импорт, эрэлт, нийлүүлэлт*

- БНХАУ-ын Засгийн газраас үйлдвэрлэлийн салбарын эрчим хүчийг хязгаарлах бодлогын нөлөөгөөр эрчим хүчний эрэлт болон үнэ бага зэрэг буурсан байна.
- Тус улсын засаг захиргаа эрчим хүчний дутагдлаас шалтгаалан дотоодын эрчим хүчний нүүрсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарч гол гурван бүс нутагт нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлага тавиад байгаа юм.

**Хүснэгт 2. Дотоодын нүүрсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилтот хэмжээ /2021 Q4/**

Нийлүүлэгч бүс	Нүүрсний орд	Хэмжээ
Шаньси муж	Жиннэнг групп	

<sup>1</sup> БНХАУ-ын ДНБ 2020 оны 3-р улиралд 4.9 хувийн өсөлттэй байв.

	Шанси коксжих нүүрсний групп	55 сая тонн
	Хуанянг	
	Лу-ан групп	
<b>Өвөр Монгол</b>	Ордос	77 сая тонн
	63-р нүүрсний уурхай	
	15-р нүүрсний уурхай	
<b>Шааньси муж</b>	Шааньси муж	65.7 сая тонн
	Юүлин бүс	

*Эх сурвалж: SXcoal, 10-р сарын 11-ний долоо хоногийн мэдээ*

- Коксжих нүүрсний үнэ 10-р сарын 22-ны байдлаар тогтворжиж эхлээд байна. Тяньжин боомт дээрх 1 тонн коксжих нүүрсний үнэ 4200 юань буюу 664 орчим ам.доллар, Шанси мужид 4060 юань буюу 635 орчим ам.доллар, Хэбей мужид 4260 юань буюу 667 орчим ам.долларт хүрсэн нь өмнөх долоо хоногтой харьцуулахад өөрчлөлтгүй байгаа тухай SXcoal мэдээллээ. Цаашид гангийн үйлдвэрлэл сэргэх эсэхээс шалтгаалан нүүрсний үнийн хөдөлгөөн тодорхойлогдох бөгөөд зах зээл хүлээлтийн байдалд шилжээд байна.
- БНХАУ-ын өмнөд бүсийн гангийн үйлдвэрлэлийн квотыг нэмэгдүүлсэн бол өвлийн улирал болон олимпын тоглолт ойртож байгаатай холбоотойгоор хойд бүсийн ган үйлдвэрлэлийн гарцыг 50 хувиар танах шийдвэр гаргасан байна. Харин БНХАУ-ын төвийн бүсийн үйлдвэрүүд эрчим хүчний хязгаарлалтаас шалтгаалан үйл ажиллагаа доголдсон нь нийт гангийн гарцад сөргөөр нөлөөлж байна.
- БНХАУ-ын коксжих нүүрсний үйлдвэрийн нөөц 10-р сарын 22-ны байдлаар өмнөх оны мөн үеэс 27.6

хувиар буурч 11.7 сая тоннд хүрчээ. Мөн гангийн үйлдвэрүүд дэх коксжих нүүрсний нөөц өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар буурч 8.9 сая тоннд хүрсэн нь тус тус 15 хоногийн нөөцийн хэмжээтэй тэнцэж байна. Импортын нүүрсний тухайд 4 боомтын коксжих нүүрсний нөөц 10-р сарын 22-ны байдлаар 4.04 сая тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар өссөн үзүүлэлт боллоо.

- БНХАУ-ын нүүрсний импорт 9-р сард 40 хувиар өссөн бөгөөд үүний гуравны хоёрыг Индонез улс бүрдүүлсэн байна. Харин Оросоос ирж буй нүүрсний импорт сүүлийн 6 сарын доод түвшинд хүрч 17.9 сая тоннд хүрэв. Индонезийн нүүрсний үнэ 10-р сарын 22-ны байдлаар 1 тонн нь 184 ам.долларт хүрч өнгөрсөн долоо хоногийн дунджаас 8 ам.доллараар нэмэгдээд байна.

*Монголын нүүрсний нийлүүлэлт*

- Монголын нүүрсний экспорт цар тахлаас шалтгаалан хязгаарлагдсан хэвээр бөгөөд Эрээн хот болон Сэхэ боомтууд Ковид-19 цар тахлын тархалттай холбоотойгоор хаагдаад байна. Харин 10-р сарын 22-ны долоо хоногийн байдлаар Гашуун Сухайт боомтоор гарах ачааны машины долоо хоногийн дундаж тоо 462 болж бага зэрэг нэмэгдсэн бөгөөд коксжих нүүрсний үнэ 2910 юань буюу 455 орчим ам.долларт тогтворжоод байна.
- Монголын нүүрсний нийлүүлэлт 9-р сард өмнөх сартай харьцуулахад 40.5 хувиар өссөн боловч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60.4 хувиар бага байна.

*Эх сурвалж:*

- Weekly report of 11<sup>st</sup> to 25<sup>th</sup> of October 2021, Sxcoal*
- Iron ore price down as Beijing moves to cool coal prices, MiningDotCom*

3

## МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ (\$) 2021/10/26	Өөрчлөлт					
		өдрийн	7 хоногийн	сарын	оны эхнээс	жилийн	
Зэсийн үнэ	9,955	-1.1%	-11.9%	6.2%	28.5%	24.3%	Зэсийн үнэ 1 тонн нь 10 мянган ам.доллар давахад ойртоод байна. Дэлхийн эрчим хүчний хямрал болон нийлүүлэлт буурсантай холбоотойгоор зэсийн үнэ 10-р сарын 26-ны байдлаар 1 тонн нь 9,955 ам.доллар буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.3 хувиар өсөв.
Төмрийн хүдрийн үнэ	122	0.3%	-0.8%	2%	-21.4%	-27.8%	Гангийн үйлдвэрлэлийн хоригоос шалтгаалан төмрийн хүдрийн эрэлт буурсан. Харин 10-р сарын 1-ний БНХАУ-ын үндэсний баяраас өмнө төмрийн хүдрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор эрэлт болон үнэ нэмэгдээд байсан хэдий ч 2021 оны 10-р сарын сүүлийн 7 хоногт эрэлт, үнэ эргэн буураад байна.
Алтны үнэ	1,793	-0.8%	1.6%	2.4%	-5.6%	-3.1%	10-р сард 1 унц алтны үнэ 1,793 ам.долларт хүрээд байна. Нийлүүлэлтээс шалтгаалсан дэлхийн инфляцын өсөлтийг Холбооны Нөөцийн банк болон бусад Төв банкууд түр зуурын үзэгдэл хэмээн үзэж байсан бол шинжээчид үнийн энэхүү өндөр өсөлт төсөөллөөс удаан хугацаанд хадгалагдахаар байгааг анхааруулж байна. Ингэснээр алтны үнэ бага зэрэг өсөхөд нөлөөллөө.
Газрын тосны үнэ (Брент)	86.4	0.5%	2.5%	8.6%	69%	55%	Дэлхий нийгэд нүүрлээд буй эрчим хүчний хямрал нь газрын тосны эрэлтийг нэмэгдүүлж,



							<p>өвлийн улирал ойртож байгаатай холбогдуулан газрын тосны үнэ нэмэгдэхээр байна. Харин ОПЕК+ нэгдлээс газрын тосны нийлүүлэлтийг 11-р сараас эхлэн 400 мянган баррелиар нэмэгдүүлэх шийдвэр гаргаад байгаа билээ<sup>2</sup>.</p>
--	--	--	--	--	--	--	---

<sup>2</sup> Австралийн нөөц эрчим хүчний байгууллагын төсөөллөөр газрын тосны 1 өдрийн хэрэглээ 2021 онд 96 сая баррель, 2022 онд 99 сая баррель, 2023 онд 104 сая баррель болж өсөхөөр байна.